

**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**  
*/шинэчилсэн/*

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү Мэдээллийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам”гэх)-ын зорилго нь хувьцаа эзэмшигчид болон сонирхсон бусад талуудад “Багануур” ХК (цаашид “Компани” гэх)-ийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, Компани нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох, хувьцаа эзэмшигчдийн зүгээс Компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Мэдээллийн үйл ажиллагааны журам нь Монгол улсын Компанийн тухай хууль, Монголын Компанийн засаглалын кодекс, энэ журам болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бурдэнэ.
- 1.3. Журмыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс батлан гаргасан үеэс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4. Мэдээллийн нээлттэй, ил тод байх журамд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:
  - 1.4.1. Тухайн мэдээллийн ач холбогдол, Компанийн бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай хүргэж байх;
  - 1.4.2. Холбогдох хууль, дүрэм, журамд заасан болон мэдээллийг нийтэд хүргэх хүртээмж, ач холбогдолтой нь уялдуулан тухайн мэдээллийг тогтсон цаг хугацаанд нь боловсруулж, нийтэд хүргэж байх;
  - 1.4.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх
  - 1.4.4. Үнэн зөв байх, тодорхой, ойлгомжтой;
  - 1.4.5. Агууллын хувьд хоёрдмол санаагүй, бүрэн дүүрэн байх;
  - 1.4.6. Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх;
  - 1.4.7. Хувьцаа эзэмшигчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх;
  - 1.4.8. Бусад мэдээллийн нээлттэй, ил тод байх үндсэн зарчмууд.

**ХОЁР. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

- 2.1. Компанийн хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.
- 2.2. Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор тус тус энэ журамд заасны дагуу нийтэд мэдээлэх ба компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
  - 2.2.1. Компанийн бизнес үйл ажиллагааны талаарх мэдээлэл
  - 2.2.2. Удирдлагын талаарх мэдээлэл
  - 2.2.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл
  - 2.2.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
  - 2.2.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

- 2.2.6. Бусад шаардлагатай мэдээлэл
- 2.3. Олон нийтэд түгээвэл зохих мэдээлэлд компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүд орж болно. Эдгээр мэдээллийг олон нийтэд тараах хугацаа, арга замыг компанийн ТУЗ, эсвэл Гүйцэтгэх удирдлага тогтооно.
- 2.4. Бусад мэдээлэлд компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, олон нийтэд хүргэх мэдээллүүд багтана. Жишээ нь: Компанийн нэвтрүүлж буй шинэ бараа үйлчилгээний тухай, компанийд болсон онцлох үйл явдлын тухай, үйл ажиллагааны тайлан гэх мэт. Эдгээр мэдээллийг компанийн Гүйцэтгэх удирдлага, холбогдох алба, хэлтсүүд хариуцан олон нийтэд хүргэнэ.
- 2.5. Байгууллагын нууцын зэрэглэл, ангилалд орсон мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд мэдээлэхгүй.

## **ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ**

- 3.1. Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр энэ журамд заасны дагуу нийтэд мэдээнэ.
- 3.2. Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:
- 3.2.1. Санхүүгийн мэдээлэл
- 3.2.1.1. Компанийн хөрөнгө, өр төлбөр хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах
- 3.2.1.2. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг дуусгавар болгох, цуцлах
- 3.2.1.3. Компани хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл
- 3.2.1.4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл
- 3.2.1.5. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах Компани төлбөрийн чадваргүй болох
- 3.2.1.6. Компанийн толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох
- 3.2.1.7. Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гарах
- 3.2.2. Санхүүгийн бус мэдээлэл:
- 3.2.2.1. Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон
- 3.2.2.2. Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанийд болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон
- 3.2.2.3. Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах
- 3.2.2.4. Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах
- 3.2.2.5. Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг барийшил өөрчлөгдсөн
- 3.2.2.6. Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл
- 3.2.2.7. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт

3.3. Компанийн энэ журмын 3.2.-т заасан болон хууль тогтоомжид ил болгохоор заасан бусад мэдээлэл өөрлөлтийг өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

## **ДӨРӨВ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- 4.1. Энэ 2.2, 3.2-т заасан мэдээллийг өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар мэдээллийн үнэн зөвийг компани хариуцна.
- 4.2. ТУЗ-ийн нарийн бигчийн дарга нь мэдээллийг нийтэд хүргэхдээ компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд тодорхой техникийн туслалцаатайгаар өөрөө байршуулна.
- 4.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэдээллийг нийтэд хүргэхдээ компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд Хөрөнгийн биржээс олгосон цахим нэр, нууц дугаарыг ашиглан байршуулна.
- 4.4. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компаниас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан үр дагаврыг хариуцна.

## **ТАВ.ХЯНАЛТ**

- 5.1. Мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажиллагааг Гүйцэтгэх удирдлага эрхлэн явуулах бөгөөд түүний ажиллагаанд ТУЗөвлөл хяналт тавьж ажиллана.
- 5.2. Мэдээллийг нээлттэй, ил тод болгоходоо нууц, дотоод мэдээллийг хууль бусаар, компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглах явдлаас Гүйцэтгэх удирдлага урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

## **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 6.1. Журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгүүлэхээр Төрийн эрх бүхий байгууллагад асуудлыг тавина.
- 6.2. Зааврыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэлд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.3. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл нь Компанийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.
- 6.4. Аливаа мэдээллийн үнэн зөвийг уг мэдээг боловсруулсан болон хянасан албан тушаалтан хариуцна.

---Оо---